



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот


Зардал гаргах тухай

Монгол улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.3, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БНХАУ –ын “CSIC Pride Nanjing Technology” ” компанийн үйлдвэрээс 2007, 2008 онуудад худалдан авсан Улаанбаатар хот, Сүхбаатар аймагт ажиллаж байгаа явуулын 724XD радаруудад засвар хийх болон явуулын радарын инженерүүдэд сургалт, семинар, хичээл үйлдвэрлэлийн дадлага явуулах ажлаар 2018 оны 7 дугаар сарын 29-нөөс 8 дугаар сарын 2-ны өдрүүдэд тус газарт ажиллах БНХАУ –ын радарын мэргэжилтнүүдийн зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Уг зардалд зориулж 6.561.430 (зургаан сая таван зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун гуч) төгрөгийн 3.500.000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас, 3.061.430 (гурван сая жаран нэгэн мянга дөрвөн зуун гуч) төгрөгийг тус газрын сургалт, семинарын хөтөлбөр, арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардлаас тус тус гаргахыг Ахлах нягтлан бодогч Д.Отгонбаярт зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ЭНХТҮВШИН